




# НИЙГМИЙН ДААТГАЛ, 2021 оны эхний 2 сард


ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ  
ᠳᠠᠠᠲᠭᠠᠯ  
ᠰᠠᠨ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэрбум төгрөг




\* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД





## ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИД ХАМРАГДАГЧИД



## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөг



## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр




Бусад гэсэн ангилалд ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, насны хишиг, цаатан иргэний тэтгэмжийг оруулсан.

## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД


Нийгмийн халамжийн тэтгэвэр

**52 738**




Нийгмийн халамжийн тэтгэмж

**64 401**



Үйлчилгээ (халамжийн, хөгжлийн)

**235 529**



**БҮГД  
352 668**

2/2021

Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 14



## Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар, зарлага 6.4 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 2 сард 476.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 35.2 (8.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 35.2 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 33.7 (10.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн 2021 оны 2 дугаар сард нийгмийн даатгалын сангийн орлого 252.8 тэрбум төгрөг, зарлага 232.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас орлого 29.6 (13.3%) тэрбум төгрөгөөр, зарлага 9.7 (4.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Нийгмийн даатгалын сангийн зарлага 2021 оны эхний 2 сард 456.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 27.3 (6.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 35.8 (10.5%) тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 1.3 (5.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2021 оны эхний 2 сард 4624 хүнд 8.9 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 962 (26.3%) хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэмжийн хэмжээ 174.7 (2.0%) сая төгрөгөөр өссөн байна.


Нийгмийн даатгалын сангаас 2021 оны эхний 2 сард 452.6 мянган хүн тэтгэвэр авсны 75.8 хувь нь өндөр насны тэтгэвэр авагчид, 15.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авагчид, 8.6 хувь нь бусад (тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр) тэтгэвэр авагчид байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, төрлөөр, 2021 оны эхний 2 сард



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангийн орлого 2021 оны эхний 2 сард 373.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 206.5 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр, зарлага 214.7 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ.

Зураг 3. Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 2 сард 2.1 (давхардсан тоогоор) сая хүнд 353.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 95.0 (4.6%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 215.1 (2.6 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 288.0 мянган төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 100.0 мянган төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг шаардлагатай хүүхдэд 16.0 мянган төгрөг, насанд хүрэгчдэд 32.0 мянган төгрөгийг тус тус олгохоор шийдвэрлэсэн юм.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, тэдгээрт олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд “Хүүхдийн мөнгөн тэтгэмж” авсан 0-18 хүртэлх насны хүүхдийн тоо 59.1 (5.2%) мянгаар, олгосон тэтгэмжийн хэмжээ 196.1 тэрбум (5.4 дахин) төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны эхний 2 сард 52.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 236 (0.4%) хүнээр буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 11.9 (59.9%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 66.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 26.8 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 6.5 хувь нь ахмад настан, 0.2 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний 2 сард 64.4 мянган хүн хамрагдсаны 81.0 хувь нь асаргааны тэтгэмжид, 19.0 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний 2 сард 16.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 3.3 (25.0%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд 240.4 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2021 оны эхний 2 сард олгожээ.

Хүснэгт 1. Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдагчид, төрлөөр

Үзүүлэлт	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	<u>2021 I-II</u> 2020 I-II	%
<b>Бүгд</b>	<b>2 083 289</b>	<b>1 805 914</b>	<b>2 044 890</b>	<b>2 139 851</b>	<b>104.6</b>	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	372 654	369 251	363 658	352 668	97.0	
Тэтгэвэр	51 390	51 117	52 974	52 738	99.6	
Тэтгэмж	77 583	65 469	69 955	64 401	92.1	
Үйлчилгээ (халамжийн, хөгжлийн)	243 681	252 665	240 729	235 529	97.8	
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	161 916	196 697	202 153	226 836	112.2	
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1 356 375	911 502	1 134 659	1 193 802	105.2	
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	37 679	20 569	22 516	30 581	135.8	
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	2 056	2 184	2 343	50	2.1	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	9 728	5 512	6 891	4 980	72.3	
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	35 728	176 396	178 678	188 787	105.7	
Насны хишиг	107 153	123 485	133 628	141 754	106.1	
Цаатан иргэний тэтгэмж	-	318	364	393	108.0	

### Ойлголт, тодорхойлолт:

**Нийгмийн даатгал** нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын сан** гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Даатгуулагч** гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

**Тэтгэвэр** гэж даатгуулагчийг өндөр наслахад насан түршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Тэтгэмж** нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг **нийгмийн халамж** гэнэ.

**Эх үүсвэр:** Нийгмийн даатгалын ерөнхий газар  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



**Мэдээлэл авах линк:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархах хуваарь:** 2021 оны 4 дүгээр сарын 15

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын  
дарга А.Амарбал  
Утас: (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын  
статистикч С.Дарьмаа  
Утас: (976-51)-263966*

